

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаа
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд дараах зүйл нэмсүгэй:

1/18 дугаар зүйл:

“18 дугаар зүйл.Гадаад улсаас цахимаар үзүүлэх үйлчилгээ

18.1.Гадаад улсаас Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлах татвар төлөгчид зайнаас цахимаар үзүүлсэн үйлчилгээнд татвар ногдуулна.

18.2.Монгол Улсад оршин суугч бус этгээд гадаад улсаас Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлах этгээдэд зайнаас, цахимаар үйлчилгээ үзүүлж, жилийн 400 сая төгрөг ба түүнээс дээш борлуулалтын орлого олсон бол оршин суугч бус этгээд нь татвар суутган төлөгчөөр бүртгүүлнэ.

18.3.Монгол Улсад оршин суугч бус этгээд нь өөрийн бараа, үйлчилгээг цахим арилжааны платформоор дамжуулан Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлах татвар төлөгчид бараа, ажил, үйлчилгээ борлуулж, жилийн 400 сая төгрөгийн орлого олсон бол цахим арилжааны платформ эрхлэгч этгээд суутган төлөгчөөр бүртгүүлнэ.

18.4.Дараах нөхцөлөөс хоёр ба түүнээс дээш нөхцөлийг хангасан үйлчилгээ авагчийг зайнаас үйлчилгээ авч буй Монгол Улсад байрлах татвар төлөгч гэнэ:

18.4.1.төлбөр гүйцэтгэсэн этгээд нь Монгол Улсад байрлах;

18.4.2.зайнаас авах үйлчилгээг ашиглах төхөөрөмжийн интернэт протокол хаяг нь Монгол Улсад байрлах;

18.4.3.татвар төлөгчийн төлбөр хийхэд ашигласан дансны мэдээлэл, банкны хаяг нь Монгол Улсад байрлах;

18.4.4.татвар төлөгчийн утасны дугаар нь Монгол Улсад хамаарах;

18.4.5.үйлчилгээ авч буй байрлал нь Монгол Улсад байрлах;

18.4.6.үйлчилгээ авч буй татвар төлөгчийн худалдаанд шаардлагатай мэдээлэл нь Монгол Улсад хамаарах.

18.5.Оршин суугч бус татвар суутган төлөгч нь борлуулалтын орлогоос 10 хувиар төлөх татварыг тодорхойлно.

18.6.Оршин суугч бус татвар суутган төлөгч нь худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн татварыг хасагдуулахгүйгээр борлуулсан бараа, ажил, үйлчилгээний үнийн дүнгээс татварыг шууд тайлагнана.

18.7.Оршин суугч бус татвар суутган төлөгч этгээд тухайн улирлын тайланг дараа сарын 10-ны өдрийн дотор харьяа татварын албанд цахимаар тушаана.

18.8.Оршин суугч бус татвар суутган төлөгч этгээд энэ зүйлд заасны дагуу тухайн улиралд төлбөл зохих татвараа тодорхойлж дараа сарын 15-ны өдрийн дотор төсөв төлнө.

Тайлбар: Энэ зүйлд заасан гадаад улсаас Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлах татвар төлөгчид зайнаас цахимаар үзүүлсэн үйлчилгээнд татвар ногдуулах харилцаа гэж олон улсын татварын харилцаанд нийтлэг ашиглагддаг “Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх явдалтай тэмцэх 1 дүгээр үйл ажиллагаа” буюу "Addressing the Tax Challenges of the Digital Economy"-г ойлгож, хуульд өөрөөр заагаагүй бол энэ үйл ажиллагааны дүрмийг баримтална.”

2/19 дүгээр зүйл:

“19 дүгээр зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт

19.1.2015 оны 07 дугаар сарын 09-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд худалдан авсан үндсэн хөрөнгөд төлсөн татварыг 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу хувь тэнцүүлэн хасагдуулж тооцно.

19.2.2015 оны 07 дугаар сарын 09-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд хамаарах ногдуулалт болон төлөлт, буцаан олголт, урамшуулал, хойшлуулан бүртгэсэн татвартай холбоотой харилцааг 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг баримтлан тодорхойлно.

19.3.Энэ хуулийн 17.2-т заасан хугацаанд хүсэлт гаргаагүй, 2025 онд татвар ногдох орлогогүй, 400 сая төгрөгт хүрээгүй этгээдийг татварын алба хялбаршуулсан горимд бүртгэж татвар төлөгчид мэдэгдэнэ.

19.4.Энэ хуулийн 18 дугаар зүйлийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

2 дугаар зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтын “хөрөнгөнөөс” гэсний өмнө “мөнгөн хөрөнгө, цахим мөнгө, виртуал” гэж, 4.1.4 дэх заалтын “бараа” гэсний өмнө “мөнгөн хөрөнгө, цахим мөнгө, виртуал хөрөнгөнөөс бусад” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтын “Монгол Улсад” гэсний өмнө “Төлөөний газартайгаас бусад” гэж, мөн зүйлийн 12.1.5 дахь заалтын “үйлчилсэн үйлчилгээ” гэсний дараа “, нисэх буудлаас үзүүлэх зорчигч үйлчилгээ, зорчигчийн аюулгүй байдлын хураамж” гэж, 13 дугаар зүйлийн 13.1.5 дахь заалтын “цагдаа,” гэсний дараа “тагнуул” гэж, 13 дугаар зүйлийн 13.5.13 дахь заалтын “заасан” гэсний дараа “таксийн үйлчилгээнээс бусад” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг:

“10.2.Бараа, ажил, үйлчилгээний борлуулалтыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12.1-д заасны дагуу хүлээн зөвшөөрч, борлуулалтын нэхэмжлэл, эсхүл төлбөрийн баримт үйлдсэнээр татвар ногдуулна.”

2/12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалт:

“12.1.6.олон улсын болон орон нутгийн нислэгт үзүүлэх агаарын навигацийн үйлчилгээ, нисэхийн үйлчилгээ, зорчигч, ачаа, шуудангийн агаарын тээврийн үйлчилгээ;”

3/14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт:

“14.1.4.Монгол Улсад оршин суугч харилцан хамааралгүй этгээдээс төлбөрийн баримтгүй худалдан авсан бараа, ажил үйлчилгээний төлбөрийг бэлэн бусаар хийсэн тохиолдолд төлбөрийн баримт үүсгэж, төлбөрийн дүнд 10 хувийн татвар шингэсэн гэж үзэн хасаж тооцож болно.”

4/17 дугаар зүйл:

“17 дугаар зүйл.Татварын хялбаршуулсан горим

17.1.Дараалсан 12 сарын хугацаанд 400 сая төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой татвар суутган төлөгчийн хүсэлтээр татварын хялбаршуулсан горимд бүртгэнэ.

17.2.Энэ хуулийн 7.1-д заасан этгээд нь татварын хялбаршуулсан горимд бүртгүүлэх хүсэлтийг татвар төлөгчийн гэрчилгээ олгосноос хойш нэг сарын дотор гаргана.

17.3.Дараах үйл ажиллагаа эрхэлдэг татвар суутган төлөгч хялбаршуулсан горимд хамрагдахгүй:

17.3.1.ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх, олборлох, ашиглах, тээвэрлэх, борлуулах;

17.3.2.согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох;

17.3.3.тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх, импортлох;

17.3.4.газрын тосны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх, газрын тос хайх, олборлох, борлуулах.

17.4.Татвар суутган төлөгчийн борлуулалтын орлогын хэмжээ нь татварын жилийн дундуур 400 сая төгрөгт хүрсэн тохиолдолд татварын хялбаршуулсан горимын

бүртгэлээс хасаж дараагийн сараас энэ хуулийн зургадугаар бүлэгт заасны дагуу татвараа тайлагнаж төлнө.

17.5.Энэ зүйлийн 22.4-т заасан татвар суутган төлөгч нь татварын хялбаршуулсан горимоос хасагдсанаас хойш дараагийн 12 сарын хугацаанд хялбаршуулсан горимд бүртгүүлэх хүсэлт гаргахгүй.

17.6.Үндсэн хөрөнгийн болон татвараас чөлөөлөгдөх бараа, ажил, үйлчилгээний борлуулалтыг энэ зүйлийн 22.1-д заасан борлуулалтын орлогод тооцохгүй.

17.7.Хялбаршуулсан горимд хамрагдсан татвар суутган төлөгчийн тухайн улиралд борлуулсан бараа, ажил, үйлчилгээний дүнгийн 90 хувьтай тэнцэх хэмжээгээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авснаар тооцон төлбөл зохих татварыг тодорхойлно.

17.8.Хялбаршуулсан горимд хамрагдах татвар суутган төлөгч этгээд тухайн улирлын тайланг дараа сарын 10-ны өдрийн дотор харьяа татварын албанд цахимаар тушаана.

17.9.Хялбаршуулсан горимд хамрагдах татвар суутган төлөгч этгээд энэ зүйлийн 16 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлж тухайн улиралд тайлагнасан төлбөл зохих татварыг дараа сарын 15-ны өдрийн дотор төсөвт төлнө.”

4 дүгээр зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийн “газрын Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогын хэмжээ нь 50 сая ба түүнээс дээш төгрөгт хүрсэн бол” гэснийг “газар нь” гэж, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “12.1 дэх хэсэг” гэснийг “12.1.1, 12.1.2, 12.1.3, 12.1.4, 12.1.7 дахь заалт” гэж, 13 дугаар зүйлийн 13.1.5 дахь заалтын “биелүүлэх” гэснийг “гүйцэтгэх” гэж, мөн заалтын “газрын” гэснийг “байгууллагын” гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “13.1.6, 13.1.9, 13.1.12, 13.1.18, 13.1.19, 13.1.20, 13.1.22, 13.1.28-д” гэснийг “13.1.12-т” гэж, мөн зүйлийн 13.5.9 дэх заалтын “боловсролын болон мэргэжлийн сургалт явуулах зөвшөөрөлтэй хувь хүн, хуулийн этгээдийн эрхлэн гүйцэтгэж байгаа дүрэмд нь заасан боловсрол, мэргэжил олгох” гэснийг “албан боловсролын” гэж, 13.5.10 дахь заалтын “эрүүл мэндийн” гэснийг “эмнэлгийн тусламж” гэж, 15 дугаар зүйлийн гарчгийн “татварыг” гэснийг “татварын хөнгөлөлт үзүүлэх,” гэж, мөн зүйлийн 15.2 дахь хэсгийн “урамшуулал олгож болно” гэснийг “татварын хөнгөлөлт үзүүлж, урамшуулал олгоно” гэж, 15.2.1 дэх заалтын “тухайн улиралд албан татвар суутган төлөгчтэй хийсэн худалдан авалтад төлсөн албан татварын 20 хүртэл хувийг” гэснийг “тухайн сарын 500,000 төгрөг хүртэлх худалдан авалтад төлсөн татварыг 100 хувь, 500,001-800,000 төгрөг хүртэлх худалдан авалтад төлсөн татварыг 50 хувь, 800,001 төгрөгөөс дээш худалдан авалтад төлсөн татварыг 20 хувиар хөнгөлж,” гэж, мөн зүйлийн 15.4 дэх хэсгийн “улиралд” гэснийг “сард” гэж, Есдүгээр бүлгийн гарчгийн “БУСАД ЗҮЙЛ” гэснийг “ТУСГАЙЛСАН ТАТВАРЫН ХАРИЛЦАА” гэж, 18 дугаар зүйлийн дугаарыг “20” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “Үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ нь 50 сая ба түүнээс дээш төгрөгт хүрч, албан татвар ногдуулан суутган авч, төсөвт төвлөрүүлэх үүрэг бүхий” гэснийг, 6 дугаар зүйлийн 6.8 дахь хэсгийн “эсхүл орлогын хэмжээ нь

албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлсэн босгын хэмжээнд хүрээгүй нь дараалсан 12 сарын албан татварын тайлангаар,” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10, 4.1.11 дэх заалтыг, 5 дугаар зүйлийн 5.5, 5.6 дахь хэсгийг, 6 дугаар зүйлийн 6.3, 6.4, 6.5, 6.6, 6.9, 6.10, 6.11 дэх хэсгийг, 7 дугаар зүйлийн 7.2.17, 7.3.2 дахь заалтыг, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг, 9 дүгээр зүйлийн 9.1.7 дахь заалтыг, 10 дугаар зүйлийн 10.3, 10.5 дахь хэсгийг, 11 дүгээр зүйлийн 11.3, 11.4 дэхь хэсгийг, 13 дугаар зүйлийн 13.1.6, 13.1.9, 13.1.10, 13.1.11, 13.1.15, 13.1.16, 13.1.17, 13.1.18, 13.1.19, 13.1.20, 13.1.21, 13.1.22, 13.1.24, 13.1.25, 13.1.26, 13.1.27, 13.1.28, 13.1.29 дэх заалтыг, мөн зүйлийн 13.5.15, 13.5.18, 13.5.19 дэх заалтыг, 13.6, 13.10 дахь хэсгийг, 14 дүгээр зүйлийн 14.1.5, 14.6.3 дахь заалтыг, мөн зүйлийн 14.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг